



Санхүүгийн тайлангийн аудитын танилцуулга

Агуулга

1. ЕРӨНХИЙ ЗҮЙЛ

2. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТЫН ОНЦЛОГ

3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ ХИЙХЭД БАРИМТАЛСАН БОДЛОГО, ГҮЙЦЭТГЭСЭН ГОРИМ СОРИЛ

4. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТЫН ДҮН

4.1. Төсвийн ерөнхийлөн захирагчийн хамрах хүрээний байгууллагуудын санхүүгийн тайлангийн аудит

4.2. Улсын төсвийн болон ТӨҮГ-ын санхүүгийн тайлангийн аудит

5. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТЫН ЗӨРЧЛИЙГ ӨМНӨХ ОНТОЙ ХАРЬЦУУЛСАН ҮЗҮҮЛЭЛТИЙН ТАЛААР

5.1. Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийг өмнөх оны үзүүлэлттэй харьцуулсан нь

5.2. Төсвийн ерөнхийлөн захирагчийн харьяа байгууллагуудын зөрчлийн судалгаа, харьцуулалт

5.3. Улсын төсвийн байгууллагуудын зөрчлийн судалгаа, харьцуулалт

6. НИЙТЛЭГ ИЛЭРЧ БАЙГАА АЛДАА ЗӨРЧИЛ

6.1. Санхүүгийн тайлангийн аудитаар илэрсэн зөрчлийн судалгаа, харьцуулалт

6.2. Санхүүгийн тайлангийн аудитаар илэрсэн зөрчлийн утга

6.3. Санхүүгийн тайлангийн аудитын сүүлийн 5 жилийн зөрчлийн судалгаа

7. ЗӨРЧЛИЙН ШАЛТГААН, ЗӨВЛӨМЖ

7.1. Зөрчил гарах болсон шалтгаан

7.2. Цаашид хэрэгжүүлэх арга хэмжээ

ТОВЧИЛСОН ҮГИЙН ЖАГСААЛТ

ЖДҮДС	Жижиг дунд үйлдвэрлэлийг дэмжих сан
МХС	Мал хамгаалах сан
НББ	Нягтлан бодох бүртгэл
ОНӨААТҮГ	Орон нутгийн өмчит аж ахуйн тооцоот үйлдвэрийн газар
ОНХС	Орон нутгийн хөгжлийн сан
СТАУС	Санхүүгийн тайлангийн аудитын удирдлагын систем
СХС	Сум хөгжүүлэх сан
ТЕЗ	Төсвийн Ерөнхийлөн Захирагч
ТӨҮГ	Төрийн өмчит үйлдвэрийн газар
ТТЗ	Төсвийн төвлөрүүлэн захирагч
ТЭДС	Тариалан эрхлэлтийг дэмжих сан
ТЭЗҮ	Техник эдийн засгийн үндэслэл
УИХ	Улсын Их Хурал
ҮАГ	Үндэсний аудитын газар
ХАК	Хувийн аудитын компани
УТҮГ	Улсын төсөвт үйлдвэрийн газар


1. ЕРӨНХИЙ ЗҮЙЛ



Санхүүгийн тайлангийн аудит нь аудит хийлгэсэн байгууллагын санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн цэвэр хөрөнгө, өмчийн өөрчлөлтийн болон мөнгөн гүйлгээний тайланг Нягтлан бодох бүртгэлийн нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчмууд, Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын стандартад нийцүүлэн үнэн зөв гаргасан эсэх талаар дүгнэлт гаргаж баталгаажуулах зорилготой.

Аудит хийхдээ Төсвийн тухай, Төрийн аудитын тухай, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулиуд болон холбогдох бусад хууль, тогтоомжийн хүрээнд Аудитын олон улсын стандарт, Санхүүгийн аудитын удирдамж-Аудитын дээд байгууллагуудын олон улсын стандарт 1000-1810, 4100-4200, нийтээр хүлээн зөвшөөрсөн бусад зарчмуудад тулгуурлаж гүйцэтгэлээ.

Санхүүгийн тайлангийн аудитаар Говь-Алтай аймаг дахь Төрийн аудитын газрын 8 аудитор, хувийн аудитын компанийн 6 аудитор нийт 2259 хүн өдөр, 1883 илүү цаг ажилласан тооцоо гарч байна.



Нэгж байгууллагын санхүүгийн тайлангийн аудитын тайлан, дүгнэлтийг <https://www.open.audit.mn/> , <https://www.audit.mn/> цахим хуудаснаас үзнэ үү.

2. АУДИТЫН ОНЦЛОГ



Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1 дэх заалт, 8 дугаар зүйлийн 8.1 дэх заалтын дагуу Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2021 оны 09 дүгээр сарын 06-ны өдрийн 60, 12 дугаар сарын 06-ны өдрийн 109 тоот тушаалаар Төсвийн тухай хуулийн 8.9 дэх заалтад хамрагдах 201 байгууллагын 283 санхүүгийн тайланд аудит хийхээс 141 санхүүгийн тайланд Говь-Алтай аймаг дахь Төрийн аудитын газрын аудиторуд, 56

санхүүгийн тайланд хувийн аудитын компаниар гэрээний үндсэн дээр аудит хийлгэхээр, төсвийн төвлөрүүлэн захирагч болон төсвийн ерөнхийлөн захирагчийн нэгтгэсэн тайлангаар 86 санхүүгийн тайланг түүвэрт хамруулахаар батлагдсан.

Мөн аймагт “Говь-Алтай аймгийн Соёл урлагийн газар”, “Алтай усан спорт чийрэгжүүлэлтийн газар”, “Алтай хот цогц үйлчилгээний газар”, “Говь-Алтай аймгийн инноваци судалгаа бизнес хөгжлийн төв” УТҮГ шинээр байгуулагдаж санхүүгийн тайлангийн аудит хийлгэх хүсэлт ирүүлж УАГ-т уламжлан аудитыг хийж гүйцэтгэлээ.

Төрийн аудитын байгууллагаас 2021 онд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын онцлогийг дурдвал:

- ✓ “Төрийн аудитын байгууллагын санхүүгийн тайлангийн аудитын заавар, аргачлал”-ыг МҮЕА-ын А/70 тушаалаар баталсан.
- ✓ “Төрийн аудитын байгууллагаас 2021-2022 онд гүйцэтгэх санхүүгийн тайлангийн аудитад баримтлах ерөнхий, чиглэл”-ийг Монгол Улсын Ерөнхий аудиторын А/111 тушаалаар баталсан.
- ✓ Санхүүгийн тайлангийн аудитыг www.fas.audit.mn цахим системийг ашиглан хийж гүйцэтгэсэн.
- ✓ Үндэсний аудитын газраас шилэн дансны хуулийн хэрэгжилтэд аудит хийх цахим систем боловсруулан хэрэгжүүлсэн.
- ✓ Засгийн газраас гарсан төсвийн хэмнэлтийн талаар авах арга хэмжээний тухай тогтоол гарсан.
- ✓ Аймаг орон нутагт гарсан онцлог шинжтэй ажил гүйлгээ, олон нийтийн анхаарал татсан эрсдэлтэй асуудлуудын талаар хэлэлцүүлэг зохион байгуулж санхүүгийн тайлангийн арга зүй, салбар бүрийн онцлогийг тусгасан ажлын баримт, нэг төвшинд шийдвэр гаргах тухай аргачлал боловсруулсан.
- ✓ Түүвэрт хамруулах байгууллагуудын эрсдэлтэй асуудал, ажлын баримтыг боловсруулж төвлөрүүлэн захирагчийн нэгтгэсэн тайлангийн аудитаар үзэхээр шийдвэрлэн хэрэгжилтийг ханган ажилласан.
- ✓ Төрийн аудитын байгууллагаас дэвшүүлсэн зорилт, ажлын байрны тодорхойлолтын дагуу санхүүгийн тайлангийн аудитын анхан шатны чанарын хяналтыг нотлох чиг үүргийн ахлах аудитор хэрэгжүүлсэн зэрэг болно.

3. БОДЛОГО, ЧИГЛЭЛ, ГОРИМ СОРИЛ



Төсвийн тухай хууль болон Төрийн аудитын тухай хуулийн хүрээнд Аудитын олон улсын стандарт, түүнд нийцүүлж Монгол Улсын Үндэсний аудитын газраас гаргасан “Төрийн аудитын байгууллагын санхүүгийн тайлангийн аудитын заавар, аргачлал”, Төрийн аудитын байгууллагаас 2021-2022 онд гүйцэтгэх санхүүгийн тайлангийн аудитад баримтлах ерөнхий, чиглэл”, бусад хууль эрх зүйн актуудыг үндэслэн аудитыг хийж гүйцэтгэлээ.

Дээрх бодлогын баримт бичгүүдийг тусгасан нэгж байгууллагын аудитын төлөвлөгөөний хүрээнд санхүүгийн тайлангийн аудитыг хийж гүйцэтгэхдээ дараах горим, сорилуудыг хэрэгжүүлсэн болно. Үүнд:

1. Аудитын төлөвлөлтийн өмнөх болон төлөвлөлтийн үе шатанд 24 байгууллагаас авсан хөндлөнгийн мэдээллийн файлаар сан үүсгэж тулган баталгаажуулалт хийлээ.
2. Аудитад ашиглах цахим мэдээллийн дундын сан үүсгэн олон нийтийн сүлжээ, мэдээллийн хэрэгсэлд тавигдсан мэдээллийг цуглуулж нэгтгэн боловсруулалт хийсний үндсэн дээр аудитад ашигласан.
3. Засгийн газраас гарсан төсвийн хэмнэлтийн талаар авах арга хэмжээний тухай тогтоолын хэрэгжилтэд горим сорил хэрэгжүүлж дүгнэлт шийдвэр өглөө.
4. Санхүүгийн программд хөтөлсөн анхан шатны бүртгэлийг хураангуй бүртгэл, ерөнхий журнал, ерөнхий дэвтрийн хөтлөлттэй тулган баталгаажуулалт хийх аудитын горим, сорилыг хэрэгжүүлсэн.
5. Тухайн байгууллагын түүвэрлэж үзсэн зардлын хувьд анхан шатны баримтаас зардлын зүйл ангийн дагуу зарцуулсан эсэхийг дансны хуулга, нягтлан бодох бүртгэлийн дүнтэй тулган баталгаажуулсан.
6. Шүүхийн шийдвэрийг үндэслэн олгосон цалингийн нөхөн олговрыг аудитаар давтан тооцоолох горим сорил хэрэгжүүлсэн.
7. Нэмэгдсэн өртгийн албан татварын хуулийн хэрэгжилтийг нэг горим сорил болгон хэрэгжүүлсэн.
8. Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийн хэрэгжилтийг нэг горим сорил болгон хэрэгжүүлсэн.
9. Хөрөнгийн тооллого, илтгэх хуудас, өмч хамгаалах зөвлөлийн шийдвэр, хөрөнгийн шилжилт хөдөлгөөн, хөрөнгө актлах шийдвэр, үлдэх өртөггүй үндсэн хөрөнгийг хэрхэн шийдвэрлэсэн эсэхийг тулган баталгаажуулсан.
10. Авлага, өглөгийн үлдэгдлийг харилцагч байгууллагуудтай тооцоо нийлж данс бүртгэлд тусгасан эсэхийг тулган баталгаажуулсан.
11. Шилэн дансны хуулиар хүлээсэн үүргийн биелэлтийг төлөвлөсөн хэмжээнд хянах үндсэн мэдээлэлтэй тулган баталгаажуулах горим сорил хэрэгжүүлсэн.
12. Татварын тайлангийн тодорхойлолтыг нэгж байгууллагын санхүүгийн тайланд тайлагнасан татварын авлага, өглөгтэй тулган баталгаажуулах горим, сорил хэрэгжүүлсэн.
13. Төсөвт бодитойгоор хохирол учруулсан зөрчилд төлбөрийн акт, цаашид хохирол учруулах нь илэрхий болсон мөнгөн дүнг тооцож холбогдох байгууллагуудад зөрчил арилгуулах албан шаардлага хүргүүллээ.

4. АУДИТЫН ДҮН



Аудитын дүнгээр Төрийн аудитын газрын хэмжээнд төсвийн ерөнхийлөн захирагчийн 1, шууд захирагчийн 137, төсвийн

төвлөрүүлэн захирагчийн 21, засгийн газрын тусгай сан, төсөл хөтөлбөрийн 20, төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдийн 15 нийт 194 санхүүгийн тайланд дүгнэлт гаргалаа. Есөнбулаг сумын ЗДТГ, “Орон сууц” ОНӨААТҮГ-ууд аудитад хамрагдаагүй. Авто тээврийн үндэсний төвийн ГАА салбар нь бие даасан санхүүгийн тайлан гаргадаггүй, Авто тээврийн үндэсний төвийн санхүүгийн нэгтгэсэн тайланд нэгтгэгдэг тул тусгайлан дүгнэлт гараагүй.

Хуульд заасан хугацаанд санхүүгийн тайлангаа гаргаж Төрийн аудитын байгууллагад ирүүлээгүйн улмаас аудит хийгдээгүй Есөнбулаг сумын Засаг даргын тамгын газрын удирдлага, санхүүгийн ажилтанд сахилгын хариуцлага оногдуулах албан шаардлагыг эрх бүхий албан тушаалтанд хүргүүлж шийдвэрүүлсэн байна.

Санхүүгийн тайлангийн аудитын мэдээллийг видео, зурагт хуудас байдлаар www.audit.mn цахим хуудас болон “Говь-Алтай аймаг дахь Төрийн аудитын газар” фейсбүүк хуудсаар дамжуулан олон нийтэд цахим хэлбэрээр мэдээлсэн.

САНАЛ ДҮГНЭЛТИЙН ХЭЛБЭР

Аймгийн хэмжээнд нийт 283 санхүүгийн тайлан гарснаас:

- Аудит хийж дүгнэлт өгсөн 194
 - Зөрчилгүй дүгнэлт 115
 - Хязгаарлалттай 78
 - Сөрөг 1
 - Дүгнэлт өгөхөөс татгалзсан 0
- Түүвэрт хамрагдсан 86
- Дүгнэлт гаргаагүй 1
- Аудитад хамрагдаагүй 2 санхүүгийн тайлан байна.

АУДИТААР ИЛЭРСЭН ЗӨРЧЛИЙН АНГИЛАЛ

Нийт байгууллагуудын санхүүгийн тайлангийн аудитаар 21,761.9 сая төгрөгийн зөрчил илрүүлж, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналтай холбоотой 9,024.9 сая төгрөгийн алдааг аудитын явцад залруулан тайлагнуулсан.


АУДИТЫН ШИЙДВЭР

Санхүүгийн тайлангийн аудитаар залруулагдаагүй 12,737.0 сая төгрөгийн зөрчлийн 643.9 сая төгрөгийн зөрчилд төлбөрийн акт тогтоож, 11,902.9 сая төгрөгийн зөрчилд зөрчил арилгуулах албан шаардлага, 14 албан тушаалтанд хариуцлага тооцох албан шаардлага, 83.6 сая төгрөгийн зөрчилд 127 заалт бүхий зөвлөмжийг хүргүүлсэн байна. Мөн гэмт хэргийн шинжтэй байж болзошгүй 106.6 сая төгрөгийн асуудлыг МУЕА-т албан бичгээр уламжилсан.


ДЭЛГЭРЭНГҮЙ МЭДЭЭЛЭЛ



Аудитад хамрагдсан 201 байгууллагын 283 санхүүгийн тайланд



Дүрслэл 1 Санхүүгийн тайлангийн аудитад хамрагдсан байгууллагуудын санал дүгнэлт



Дүрслэл 2 Санхүүгийн тайлангийн аудитад хамрагдсан байгууллагуудын зөрчлийн судалгаа

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТЫН ҮР НӨЛӨӨ:

Байгууллагын санхүүгийн тайлан стандартын дагуу илэрхийлэгдэж төрийн байгууллага, ард иргэдийг үнэн зөв мэдээллээр хангаж шийдвэр гаргалтад нөлөөлсөн.

Санхүү, төрийн сангийн хэлтсээс төсвийн ерөнхийлөн захирагчийн хүрээний төсөвт байгууллагуудад мөрдөх нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг боловсруулсан.

Аймгийн хяналт шинжилгээ, үнэлгээний хэлтэст аудитын шийдвэрийг хэрэгжүүлэх асуудлыг хариуцсан албан тушаалтныг томилон ажиллуулж байна.

Нийгмийн даатгалын хэлтэстэй хамтран ажилласнаар ажилтнуудын цалинг дутуу тайлагнах зөрчил эрс буурсан.

Татварын хэлтэстэй хамтран ажилласнаар бэлтгэн нийлүүлэгчээс нийлүүлсэн бараа ажил үйлчилгээний төлбөр татварын нэвтрэлтийн нэгдсэн системд бүртгэгдээгүй зөрчил өмнөх онд 5,643.8 сая төгрөг байсан бол тайлант онд 976.8 сая төгрөг болж буурсан. Үүгээр татвараас зайлсхийх асуудлыг бууруулж төсвийн орлогын баазыг нэмэгдүүлсэн.

Шилэн дансны цэс хөтлөлт сайжирч хуулийн хариуцлага тооцогдох тоо хэмжээ буурсан.



Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан иргэнд олгох нэг удаагийн тэтгэмжийн хугацааны зөрчил арилсан.

Хүнсний материалын нөөцийг зохистой төвшинд бүрдүүлснээр хэрэгцээгүй бүтэгдэхүүн их хэмжээгээр нөөцлөх, хугацаа дууссан хүнсийг акталж төсвийг үр ашиггүй зарцуулах эрсдэл арилсан. Мөн мал, өвсний нөөцийн бүртгэл тодорхой хэмжээгээр сайжирсан.

СХС-ийн хувьд зээлийн гэрээний хугацаа дууссан, чанаргүй зээлдэгчийн тоо, авлагын дүн буурсан үзүүлэлттэй байна.

Аймгийн Прокурорын газартай хамтарч ажилласнаар 47 иргэнтэй холбоотой 230.9 сая төгрөгийн шүүхийн захирамж гаргуулсан байна.

4.1.ТЕЗ-ИЙН ХАМРАХ ХҮРЭЭНИЙ БАЙГУУЛЛАГУУДЫН САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ:

Төсвийн ерөнхийлөн захирагчийн санхүүгийн нэгтгэсэн тайланд төсөвт байгууллагын 156 санхүүгийн тайлан, 59 төсөл сан, 20 төрийн сан, 13 орон нутгийн өмчит аж ахуйн нэгж бүгд 248 санхүүгийн тайланг хамруулан нэгтгэсэн байна. **Дүгнэлтийн хэлбэр /Төсвийн ерөнхийлөн захирагчийн харьяа байгууллага /**

ТЕЗ-ийн нэгтгэсэн тайланд нэгтгэгдсэн 248 санхүүгийн тайланг аудит хийсэн хэлбэр, дүгнэлтийн хувьд задалж харуулбал:

Аудит хийж дүгнэлт өгсөн 160

- ✚ Зөрчилгүй санал дүгнэлт 87
- ✚ Хязгаарлалттай санал дүгнэлт 72
- ✚ Сөрөг санал дүгнэлт 1
- ✚ Дүгнэлт өгөхөөс татгалзсан 0
- ✚ Аудитад хамрагдаагүй 2
- ✚ Түүвэрт хамрагдсан 86



Дүрслэл 3 ТЕЗ-ын хамрах хүрээний байгууллагуудын санал дүгнэлт

Аудитаар илэрсэн зөрчлийн ангилал /ТЕЗ/

Санхүүгийн тайлангийн аудитаар ТЕЗ-ийн нэгтгэсэн тайланд нэгтгэгддэг нэгж тайлангуудад нийт 18,205.6 сая төгрөгийн алдаа зөрчил илэрүүлсэн. Нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналтай холбоотой 6,718.3 сая төгрөгийн алдааг аудитын явцад залруулан тайлагнуулсан.

Аудитын шийдвэр /Төсвийн ерөнхийлөн захирагчийн харьяа байгууллага /

ТЕЗ-ийн хамрах хүрээний байгууллагуудын санхүүгийн тайлангийн аудитаар илэрсэн залруулагдаагүй 11,487.4 сая төгрөгийн зөрчилд 559.2 сая төгрөгийн төлбөрийн акт тогтоож, 10,811.5 сая төгрөгийн зөрчил арилгах албан шаардлага хүргүүлэн, алдаа зөрчил гаргасан 14 албан тушаалтанд хариуцлага оногдуулах албан шаардлага хүргүүлж, гэмт хэргийн шинжтэй байж болзошгүй 106.6 сая төгрөгийн 5 асуудлыг МУЕА-т албан бичгээр хүргүүлж, 10.0 сая төгрөгийн 116 зөвлөмжийг өгсөн.



Дүрслэл 4 ТЕЗ-ийн харьяа байгууллагын зөрчлийн судалгаа

Тайлант онд илэрсэн нийт зөрчлийн 55% буюу 10,021.1 сая төгрөгийг орон нутгийн төсөвт байгууллага, 31% буюу 5,554.2 сая төгрөгийг орон нутгийн өмчит үйлдвэрийн газрууд, 7% буюу 1,316.5 сая төгрөгийг ТЕЗ-ийн аудитаар түүвэрт хамрагдсан байгууллагууд, 6% буюу 1,079.3 сая төгрөгийг Засгийн газрын тусгай сан, 1% буюу 234.5 сая төгрөгийн зөрчлийг ТТЗ-ийн аудитаар түүвэрт хамрагдсан байгууллагуудад гарсан зөрчил тус тус эзэлж байна.

Төлбөрийн актын 46% буюу 256.2 сая төгрөгийг орон нутгийн өмчит үйлдвэрийн газрууд, 30% буюу 168.6 сая төгрөгийг сум хөгжүүлэх сан, тариалан эрхлэлтийг дэмжих сан, мал хамгаалах сан, 20 % буюу 112.0 сая төгрөгийг төсөвт байгууллага, 2% буюу 11.7 сая төгрөгийг ТЕЗ-ийн аудитаар түүвэрт хамрагдсан байгууллагууд, 2% буюу 10.7 сая төгрөгийг ТТЗ-ийн аудитаар түүвэрт хамрагдсан төсөвт байгууллагуудад гарсан зөрчил тус тус эзэлж байна.

Зөрчил арилгуулах албан шаардлагын 59.2% буюу 6,403.8 сая төгрөгийг орон нутгийн төсөвт байгууллага, 31.2% буюу 3,375.8 сая төгрөгийг орон нутгийн өмчит үйлдвэрийн газрууд, 4.5% буюу 481.3 сая төгрөгийг ТЕЗ-ийн аудитаар түүвэрт хамрагдсан байгууллагууд, 3.4% буюу 365.1 сая төгрөгийг Засгийн газрын тусгай сангууд, 1.7% буюу 185.5 сая төгрөгийг ТТЗ-ийн аудитаар түүвэрт хамрагдсан байгууллагууд тус тус эзэлж байна.

Хариуцлага тооцох албан шаардлагын 86% буюу 12 орон нутгийн төсөвт байгууллага, 14 % буюу 2 орон нутгийн өмчит үйлдвэрийн газруудад гарсан зөрчил эзэлж байна.

Орлогын
Төлбөрийн
Засаг
Засаг

4.2. УЛСЫН ТӨСВИЙН БОЛОН ТӨҮГ-УУДЫН САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ:

Энэ ангилалд улсын төсвийн байгууллагын 29, сангийн 1, ТӨҮГ-ын 4, ТТЗ-ийн 1 нийт 35 санхүүгийн тайлан гарсан байна.

Дүгнэлтийн хэлбэр / Улсын төсвийн болон ТӨҮГ-ууд/

Улсын төсвийн болон ТӨҮГ-уудын тайланд аудит хийсэн хэлбэр, дүгнэлтийн хувьд задалж харуулбал:

Аудит хийж дүгнэлт өгсөн 34

- Зөрчилгүй санал дүгнэлт 28
- Хязгаарлалттай санал дүгнэлт 6
- Сөрөг санал дүгнэлт 0
- Дүгнэлт өгөхөөс татгалзсан 0
- Аудитын дүгнэлт гараагүй 1



Дүрслэл 5 Улсын төсвийн байгууллагуудын санал дүгнэлт

Аудитаар илэрсэн зөрчлийн ангилал Улсын төсвийн болон ТӨҮГ-ууд/

Улсын төсвийн болон ТӨҮГ-ын санхүүгийн тайлангийн аудитаар нийт 3,556.3 сая төгрөгийн зөрчил илрүүлсэн. Нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналтай холбоотой 2,306.6 сая төгрөгийн алдааг аудитын явцад залруулан тайлагнуулж зөрчлийг арилгасан байна.

Аудитын шийдвэр / Улсын төсвийн болон ТӨҮГ-ууд/

Улсын төсвийн болон ТӨҮГ-ын санхүүгийн тайлангийн аудитаар илэрсэн залруулагдаагүй 1,249.7 сая төгрөгийн зөрчилд 84.7 сая төгрөгийн төлбөрийн акт тогтоож, 1,091.4 сая төгрөгийн зөрчил арилгуулах албан шаардлага, 73.6 сая төгрөгийн 13 зөвлөмжийг өгсөн.



Дүрслэл 6 Улсын төсвийн байгууллагын зөрчлийн судалгаа

Энэ ангилалд илэрсэн нийт зөрчлийн 86.1% буюу 3,062.9 сая төгрөгийг улсын төсвийн байгууллагууд, 13% буюу 461.6 сая төгрөгийн зөрчлийг төрийн өмчит үйлдвэрийн газрууд, 0.4% буюу 16.0 сая төгрөгийн Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сан, 0.4% буюу 15.8 сая төгрөгийг Нийгмийн даатгалын нэгтгэсэн тайланд илэрсэн зөрчил тус тус эзэлж байна.

Төлбөрийн актын 97% буюу 82.3 сая төгрөгийг төсвийн байгууллагууд, 3% буюу 2.4 сая төгрөгийг Засгийн газрын тусгай санд илэрсэн зөрчил эзэлж байна.

Зөрчил арилгуулах албан шаардлагын 62.6% буюу 683.5 сая төгрөгийг улсын төсөвт байгууллага, 35.4% буюу 386.1 сая төгрөгийг төрийн өмчит үйлдвэрийн газрууд, 1.2% буюу 13.6 сая төгрөгийг Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сан, 0.8% буюу 8.2 сая төгрөгийг Нийгмийн даатгалын нэгтгэсэн тайланд илэрсэн зөрчил тус тус эзэлж байна

5. АУДИТЫН ЗӨРЧЛИЙГ ӨМНӨХ ОНТОЙ ХАРЬЦУУЛСАН ҮЗҮҮЛЭЛТИЙН ТАЛААР



Тайлант оны санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийг өмнөх оны аудитаар илэрсэн зөрчилтэй харьцуулахад дараах байдалтай байна.

5.1 Санхүүгийн тайлангийн аудитаар илэрсэн нийт зөрчлийг харьцуулан харуулбал:

№	Тайлант он	Дүгнэлт				Үүнээс /сая.төг/							
		Зөрчилгүй	Хязгаарлалттай	Сөрөг	Дүгнэлт өгөхөөс	Нийт илрүүлсэн зөрчил	Залруулсан	Төлбөрийн акт	Албан шаардлага		Зөвлөмж		МУ ЕА-г санал хүргүүлсэн
									зөрчил арилгуулах	хариуцлага тооцох/тоо/	Тоо	мөнгөн дүн	
1	2020 он	153	42	3		22,478.3	6,740.1	886.9	6,661.8	46	236	8,189.5	
2	2021 он	115	78	1		21,761.9	9,024.9	643.9	11,902.9	14	129	83.6	106.6
Харьцуулалт		38	-36	2	0	716.4	(2,284.8)	243.0	(5,241.1)	32	107	8,105.9	(106.6)

Хүснэгт 1 Санхүүгийн тайлангийн аудитаар илэрсэн зөрчлийн судалгаа

Дээрх харьцуулалтаас илт өссөн үзүүлэлттэй 2 асуудлыг тодруулбал:

1. Нягтлан бодогч нягтлан бодох бүртгэлийг олон улсын стандартын дагуу үнэн зөв бүртгэхгүй, санхүүгийн тайланд авлага, өглөг, хөрөнгийг зөрүүтэй тайлагнах, шилжиж ирсэн болон хөрөнгө оруулалтаар хийгдсэн хөрөнгийг данс бүртгэлд тусгаагүй, бэлтгэн нийлүүлэгчээс нийлүүлсэн бараа ажил үйлчилгээний төлбөрийн дүн татварын нэгдсэн системд бүртгэгдээгүй буюу зөрүүтэй тайлагнасан алдааг аудитын явцад залруулснаар залруулгын дүн өссөн.
2. Санхүүгийн тайлангийн татварын авлага, өглөгийг татварын нэвтрэлтийн нэгдсэн системд нэгтгэгдсэн дүнтэй тулган баталгаажуулахад 1,430.6 сая төгрөгийн зөрүүтэй байснаас 277.9 сая төгрөгийг залруулан бүртгэж 1,152.7 сая төгрөгийн зөрчлийг арилгах албан шаардлага хүргүүлснээр албан шаардлагын дүн өссөн.

5.2 ТЕЗ-ийн хамрах хүрээний байгууллагуудын тайлант он өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар илэрсэн зөрчлийг харьцуулан харуулбал:

Тайлант оны аудитын дүгнэлтийг өмнөх онтой харьцуулахад “Зөрчилгүй санал дүгнэлт” 31 буурсан, “Хязгаарлалттай санал дүгнэлт” 31 өссөн, “Сөрөг санал дүгнэлт” 2 буурсан үзүүлэлттэй байна.

№	Дүгнэлт	Үүнээс /сая.төг/
---	---------	------------------



	Тайлант он				Илрүүлсэн зөрчил	Залруулсан	Төлбөрийн акт	Албан шаардлага		Зөвлөмж		МУ-ын ЕА-т санал хүргүүлсэн
		Зөрчилгүй	Хязгаарлалттай	Сөрөг				зөрчил арилгуулах	хариуцлага тооцох /тоо/	Тоо	мөнгөн дүн	
1	2020 он ТЕЗ	118	41	3	20,708.5	6,245.6	831.6	6,437.6	43	192	7,193.7	
2	2021 он ТЕЗ	87	72	1	18,205.6	6,718.2	559.2	10,811.6	14	116	10.0	106.6
Харьцуулалт		31	-31	2	2,502.9	-472.6	272.4	-4,374.0	29	76	7,183.7	106.6

Хүснэгт 2 ТЕЗ-ийн харьяа байгууллагын санхүүгийн тайлангийн аудитаар илэрсэн зөрчлийн судалгаа

Тайлант оны зөрчлийг өмнөх оны зөрчилтэй харьцуулахад 2,502.9 сая төгрөгөөр буурсан, аудитын залруулга 472.6 сая төгрөгөөр өссөн, төлбөрийн акт 272.4 сая төгрөгөөр буурсан, зөрчил арилгуулах албан шаардлага 4,374.0 сая төгрөгөөр өссөн, хариуцлага тооцох албан шаардлага 29-өөр буурсан, зөвлөмж 7,183.7 сая төгрөгөөр буурсан үзүүлэлтэй, тайлант онд гэмт хэргийн шинжтэй байж болзошгүй 106.6 сая төгрөгийн 6 асуудлыг Монгол Улсын Ерөнхий аудитор албан бичгээр хүргүүлсэн байна.

5.3 Улсын төсвийн болон ТӨҮГ-ын тайлант он өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар илэрсэн зөрчлийг харьцуулан харуулбал:

№	Тайлант он	Дүгнэлт				Илрүүлсэн зөрчил	Үүнээс /сая,төг/					
		Зөрчилгүй	Хязгаарлалттай	Сөрөг	Дүгнэлт өгөхөөс татгалзсан		Залруулсан	Төлбөр-ийн акт	Албан шаардлага		Зөвлөмж	
									зөрчил арилгуулах	хариуцлага тооцох /тоо/	Тоо	мөнгөн дүн
1	УТБ /2020 он/	35	1			1,769.8	494.5	55.3	224.2	3	44	995.8
2	УТБ/ 2021 он	28	6			3,556.3	2,306.6	84.7	1,091.4		13	73.6
Харьцуулалт		-7	5	0	0	1,786.5	1,812.1	29.4	867.2	-3	31	-922.2

Хүснэгт 3 Улсын төсвийн байгууллагын санхүүгийн тайлангийн аудитаар илэрсэн зөрчлийн судалгаа

Тайлант оны аудитын дүгнэлтийг өмнөх онтой харьцуулахад “Зөрчилгүй санал дүгнэлт” 7-оор буурсан, “Хязгаарлалттай санал дүгнэлт” 5-аар өссөн үзүүлэлттэй байна.

Тайлант оны зөрчлийг өмнөх оны зөрчилтэй харьцуулахад 1,786.5 сая төгрөгөөр , аудитын залруулга 1,812.1 сая төгрөгөөр, төлбөрийн акт 29.4 сая төгрөгөөр, зөрчил арилгуулах албан шаардлага 867.2 сая төгрөгөөр тус тус өссөн, хариуцлага тооцох албан шаардлага 3-аар буурсан, зөвлөмж 922.2 сая төгрөгөөр буурсан үзүүлэлтэй байна.

6. НИЙТЛЭГ ИЛЭРЧ БАЙГАА АЛДАА ЗӨРЧИЛ




Төсвийн захирагчийн эрх үүрэг, хэрэгжүүлэх арга хэмжээ, төсвийн зарчим, төсвийн хөрөнгийг хэрхэн зарцуулах талаар жил бүрийн төсвийн тухай хуульд дэлгэрэнгүй тусган холбогдох хөтөлбөр, арга хэмжээг хэрэгжүүлэхтэй нь холбогдуулан төсөв баталж хуваарилдаг. Энэхүү батлагдсан төсвийг хэмнэлттэй, үр ашигтай зарцуулах, үнэн зөв тайлагнах эрх, үүргийг хуулийн хүрээнд төсвийн захирагч хэрэгжүүлдэг.

Санхүүгийн тайлангийн аудитаар тухайн төсвийн захирагчийн гаргасан санхүүгийн тайлан илчлэл толилуулга үнэн зөв илэрхийлэгдсэн эсэхийг аудитын байгууллага тодорхой горим сорил хэрэгжүүлэн үүсэх магадлалтай эрсдэлийн дүнд үндэслэн түүвэрлэн авч үзэж дүгнэлт гаргадаг.

Санхүүгийн тайлангийн аудитаар нийтлэг дараах төрлийн зөрчил илэрч байна. Үүнд:

- ✓ Орон нутгийн орлогын төлөвлөгөөг тасалсан, түрээсийн орлогыг орон нутгийн төсөвт төвлөрүүлээгүй 1,040.5 сая төгрөгийн,
- ✓ Худалдан авах ажиллагаа зохион байгуулаагүй, тендерт шалгараагүй компаниас худалдан авалт хийсэн 888.0 сая төгрөгийн,
- ✓ Авлага, өглөгийг нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу харилцагч байгууллагуудтай тооцоо нийлж тулган баталгаажуулаагүй, барагдуулах талаар тодорхой ажил зохион байгуулаагүй 528.5 сая төгрөгийн,
- ✓ Бэлтгэн нийлүүлэгчээс нийлүүлсэн бараа ажил үйлчилгээний төлбөрийн дүн татварын нэвтрэлтийн нэгдсэн системд бүртгэгдээгүй 976.8 сая төгрөгийн,
- ✓ Төсөвт байгууллага, төрийн болон орон нутгийн өмчийн хуулийн этгээдийн санхүүгийн тайлан дахь татварын авлага, өглөг нь татварын тодорхойлолтоос зөрүүтэй 1,152.6 сая төгрөгийн,
- ✓ Хөрөнгийн тооллого хийгээгүй, тооллогын комиссын гарын үсгээр баталгаажуулдаггүй, зөрүүтэй, үлдэх өртөгтэй хөрөнгө акталсан, акталж устгасан, шилжүүлсэн хөрөнгийн дүн аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Тэргүүлэгчдийн тогтоолоос зөрүүтэй, данс бүртгэлд тусгаагүй 2,906.3 сая төгрөгийн,
- ✓ Засгийн газрын тусгай сангуудаас авсан зээлийг гэрээт хугацаанд төлөөгүй, зээлийн гэрээ дууссан зээлдэгчдийн зээлийг Шүүхэд хандаж шийдвэр гаргуулаагүй 451.7 сая төгрөгийн,
- ✓ Төсвийн хэмнэлтийн горимыг зөрчиж тавилга худалдан авч, өндөр насны тэтгэвэр тогтоолгож чөлөөлөгдсөн ажилтан, албан тушаалтны оронд нөхөн томилгоо хийсэн, авто машин худалдан авсан, шагнал урамшуулал, баяр ёслол тэмдэглэхэд зориулж төсвөөс зарцуулалт хийсэн 402.3 сая төгрөгийн,
- ✓ Удирдлагын буруутай шийдвэрээр ажлаас халагдсан ажилтанд Шүүхийн шийдвэрээр цалингийн нөхөн олговрыг олгосон бөгөөд буруутай этгээдээс нэхэмжлээгүй байгууллагын төсөв хохирол учруулсан 144.9 сая төгрөгийн,
- ✓ Санхүүгийн тайлангийн тайлагналтай холбоотой зардлыг зүйл анги зөрчиж гүйлгээ хийсэн, зардлыг зориулалт бусаар зарцуулсан, зардлыг тооцооны дансаар дамжуулалгүйгээр шууд зардалд тайлагнасан, тайлангийн үзүүлэлтийг зөрүүтэй тайлагнасан 1,993.5 сая төгрөгийн,
- ✓ Шилэн дансны цахим системд мэдээллийг хугацаанд нь мэдээлэхгүй, мэдээллийг оруулахдаа нотлох баримтыг хавсаргаагүй зөрчил илэрч байна.

6.1 Санхүүгийн тайлангийн аудитаар давтан гарсан зөрчлийг өмнөх онтой харьцуулбал:



Дүрслэл 7 Санхүүгийн тайлангийн аудитаар нийтлэг илэрсэн зөрчлийн судалгаа

Үндсэн хөрөнгө, бараа материалын бүртгэл, зарцуулалттай холбоотой зөрчил 2,386.9 сая төгрөгөөр өссөн үзүүлэлтэй байна. Батлагдсан орон тоо, худалдан авах ажиллагаа, авлага, өглөг, нэмэгдэх өртгийн албан татварын хэрэгжилттэй холбоотой, татварын тодорхойлолт, тусгай сантай холбоотой зөрчлүүд тодорхой хэмжээгээр буурсан боловч давтан гарсаар байна.

6.2 Санхүүгийн тайлангийн аудитаар давтан гарсан, тайлант оны илэрсэн зөрчлийг хувьд ихэнх байгууллагад гарсан 3 төрлийн зөрчлийг утгаар нь ангилж харуулбал:

Санхүүгийн тайлангийн аудитаар хөрөнгөтэй холбоотой зөрчил 2,906.3 сая зөрчлийг утгаар нь задалж харуулбал:

	Зөрчлийн утга	Мөнгөн дүн /сая.төг/	Хувь
1	Хөрөнгийн тооллогыг чанаргүй нэр төдий хийдэг, тооллогын комиссын гарын үсгээр баталгаажуулдаггүй	2,095.0	72%
2	Сумдын ЗДТГ-т бүртгэлтэй малыг бодитоор тоолоогүй, малчидтай байгуулсан гэрээг дүгнээгүй, гэрээний хугацаа дууссан байхад дараагийн өрхөд шилжүүлээгүй	364.1	13%
3	Үндсэн хөрөнгийг актлаж устгахдаа аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Тэргүүлэгчдийн тогтоолоос зөрүүтэй хасаж тайлагнасан	66.7	2%
4	Сумдын ЗДТГ-ын мотоциклийг дуудлага худалдаагаар үнэ тогтоон борлуулсан боловч төсөвт төвлөрүүлээгүй	2.6	0%
5	Үлдэх өртөгтэй, тайлант онд их хэмжээний засвар хийсэн автомшин акталсан	262.0	9%
6	Тайлант онд бий болсон хөрөнгийг данс бүртгэлд тусгаагүй, биет тооллогоор хөрөнгө дутагдсан	18.1	1%
7	Эмийг зохих байгууллагын зөвшөөрөлгүйгээр актлаж, устгасан	26.9	1%
8	Үндсэн хөрөнгийн шинж чанартай хөрөнгийг бараа материалд дансанд орлогоор бүртгэсэн	6.5	0%
9	Аймгийн аюулгүйн нөөцийн өвс, тэжээлийн тооцоо нийлж авлагыг бүрэн барагдуулаагүй, борлуулсан орлогыг дансанд буцаан төвлөрүүлээгүй	48.9	2%
10	Үндсэн хөрөнгийн шинж чанартай хөрөнгийг бараа материал дансанд бүртгэж шаардах хуудсаар зарлагдсан	15.2	1%
	Дүн	2,906.3	100%

Хүснэгт 4 Санхүүгийн тайлангийн аудитаар хөрөнгөтэй холбоотой илэрсэн зөрчлийн судалгаа



Дээрх үзүүлэлтээс харахад хөрөнгийн тооллогыг хуулийн хугацаанд хийж баталгаажуулдаггүй, дансанд бүртгэлтэй мал амьтдыг биет тооллогод хамруулдаггүй, гэрээний дагуу дараагийн өрхөд шилжүүлдэггүй, үлдэх өртөгтэй хөрөнгө акталсан зэрэг зөрчил нь төрийн албан хаагчийн хуульд заасан үүргээ хэрэгжүүлэхгүй, ажлын хариуцлагагүй үйлдлээс шууд хамааралтай байна.

Мөн Орон нутгийн өмчийн газар нь өөрийн чиг үүрэгт заасан хяналтаа хангалттай хэрэгжүүлэхгүй, өмч эзэмших гэрээг үнэн зөв, бүрэн дүгнэж ажиллаагүйтэй холбоотой байна. Эдгээр зөрчлийг арилгаж дахин давтан гаргахгүй байх албан шаардлагыг тус газарт хүргүүлсэн.

Засгийн газрын тусгай сантай холбоотой

Санхүүгийн тайлангийн аудитаар тусгай сантай холбоотойгоор 451.8 сая төгрөгийн зөрчлийг утгаар нь задалж харуулбал:

	Зөрчлийн утга	Мөнгөн дүн /сая.төг/	Хувь
1	Зээлдэгчийн гэрээний хугацаа дууссан байхад үндсэн төлбөр, хүүг төлүүлээгүй,	193.6	43%
2	Хугацаа дууссан зээлдэгчийн авлагыг Шүүхэд хандаж шийдвэр гаргуулаагүй	0.1	0%
3	Эвлэрлийн гэрээний хугацаа дууссан зээлдэгчийн авлагыг албадан гүйцэтгүүлэх шийдвэр гаргуулан ШШГА-тай гэрээ байгуулж барагдуулах арга хэмжээ аваагүй	127.6	28%
4	Монгол банкны зээлийн мэдээллийн санд СХС-ийн зээлийн мэдээллийг зөрүүтэй оруулсан	130.5	29%
	Дүн	451.8	100%

Хүснэгт 5 Санхүүгийн тайлангийн аудитаар Засгийн газрын тусгай сантай холбоотой илэрсэн зөрчлийн судалгаа

Засгийн газрын тусгай сангийн хувьд зээлийн эргэн төлөлтийг гэрээний хугацаанд төлүүлдэггүй, хугацаа дууссан зээлийн авлагыг барагдуулах талаар эрх бүхий байгууллагатай хамтарч ажиллаагүй, Монгол банкны зээлийн мэдээллийн санд мэдээллийг зөрүүтэй оруулдаг зөрчил жил бүр давтан гарч байна. Тухайлбал: Аймгийн Жижиг дунд үйлдвэрлэлийг дэмжих сангаас зээл авсан боловч гэрээний үүргээ хэрэгжүүлээгүй 3 зээлдэгчтэй холбоотой 198.7 сая төгрөгийн үндсэн зээл, 9.3 сая төгрөгийн хүү, 102.7 сая төгрөгийн алдангийг төлүүлэхээр төлбөрийн акт тогтоосон. АЗДТГ-аас дээрх 310.8 сая төгрөгийг төлүүлэхээр аймгийн Прокурорын газарт хандсан боловч үндсэн зээл болох 197.9 сая төгрөгийг гаргуулахаар бусад хэсгийг хэрэгсэхгүй болгон шийдвэрлэгджээ. Дээрх үйлдэлд дараагийн шатны арга хэмжээг аймгийн ЗДТГ-аас авч ажиллаагүй, тухайн аж ахуйн нэгжид давуу байдал үүсгэсэн байсан.

Төсвийн ерөнхийлөн захирагчийн санхүүгийн нэгтгэсэн тайлангаар жил бүр албан тушаалтныг үндэслэлгүйгээр ажлаас чөлөөлсөн, халсны улмаас төсвөөс олгосон төлбөрийг нөхөн төлүүлэх ажил зохион байгуулах заалттай албан шаардлагыг Засаг даргад хүргүүлдэг. Албан шаардлагын дагуу аймгийн Санхүүгийн хяналт, аудитын албанаас Захиргааны ерөнхий хуулийн 103 дугаар зүйлд заасан хохирлыг төлүүлэх үүргийн хүрээнд нэхэмжлэлийг Говь-Алтай аймгийн анхан шатны шүүхэд гаргахад нэхэмжлэх эрхгүй үндэслэлээр бүхэлд хэрэгсэхгүй болгосон боловч дахин гомдол гаргаагүй үр дүн гараагүй байна.

Прокурорын газарт “сум хөгжүүлэх сангаас олгосон 58 зээлдэгчтэй холбоотой 327.5 сая төгрөгийн зээлийн төлөлт хийгдээгүй төр хохирч байгаа үйлдэл”-д төрийг төлөөлж хохирлыг барагдуулах албан бичгийг хүргүүлсэн.



Тайлангийн уялдаа холбоо, тайлагналтай холбоотой:


Санхүүгийн тайлангийн аудитаар санхүүгийн тайлагналттай холбоотой 1,985.6 сая төгрөгийн зөрчлийг утгаар нь задалж харуулбал:

	Зөрчлийн утга	Мөнгөн дүн /сая.төг/	Хувь
1	Программаар тайлангаа гаргаагүй, нягтлан бодох бүртгэл хөтлөлт хангалтгүй	50.7	3%
2	Хандив тусламж болон үнэ төлбөргүй ирсэн хөрөнгийг данс бүртгэлд тусгаагүй	23.5	1%
3	Анхан шатны баримтгүй гүйлгээг хийж зардлаар хүлээн зөвшөөрч тайлагнасан	78.0	4%
4	Зардлын зүйл анги зөрчин гүйлгээ хийсэн	80.3	4%
5	Зардлыг зориулалт бусаар зарцуулсан	21.5	1%
6	Санхүүгийн тайлангийн үзүүлэлтийг зөрүүтэй тайлагнасан	169.3	9%
7	Няrvын тайлан нягтлан бодох бүртгэл хоорондоо зөрүүтэй	332.3	17%
8	Зардлыг тооцооны дансаар дамжуулаагүй шууд зардалд тайлагнасан	1,229.8	62%
	Дүн	1,985.6	100%

Санхүүгийн тайлагналтай холбоотой зөрчил нягтлан бодогчийн мэдлэг ур чадвар, хууль эрх зүй, санхүүгийн программын ашиглалттай холбоотой. Эдгээр зөрчлийн хувьд зөрүүтэй тайлагнасан зөрчлийг аудитын явцад залруулж, залруулах боломжгүй зөрчилд зөрчил арилгуулах албан шаардлага хүргүүлсэн.

6.3 Санхүүгийн тайлангийн аудитын сүүлийн 5 жилийн зөрчлийн судалгааг харьцуулбал

Санхүүгийн тайлангийн аудитын 5 жилийн судалгаанаас харахад аудитын залруулга, албан шаардлага өссөн, төлбөрийн акт, хууль хяналтын байгууллагад өгсөн шийдвэр буурсан үзүүлэлттэй байна.



Дүрслэл 7 Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн судалгаа /5 жилээр/

Хариуцлага тооцох албан шаардлага



Санхүүгийн тайлангийн аудитаар өмнөх онд илэрсэн зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх талаар өгсөн албан шаардлага, зөвлөмжийг үнэлснээр аудитын зөрчил, албан тушаалтны ажилдаа хариуцлагагүй хандаж сахилгын хариуцлага тооцуулах албан шаардлагын тоо буурсан байгаа нь Төрийн аудитын тухай хуулийн өөрчлөлттэй холбоотой.

7. ЗӨРЧЛИЙН ШАЛТГААН, ЗӨВЛӨМЖ

ЕРӨНХИЙ ДҮГНЭЛТ: АУДИТЫН МӨРӨӨР АЖИЛ ЗОХИОН БАЙГУУЛСАН БОЛОВЧ ХЭРЭГЖИЛТИЙГ ХАНГУУЛЖ, ҮР ДҮНГ ТООЦОХГҮЙ БАЙНА.

ЗӨРЧИЛ ГАРАХ БОЛСОН ШАЛТГААН

- ✓ Байгууллагын удирдлага, санхүүгийн ажилтны ажлын байрны тогтворгүй байдал
- ✓ Байгууллагын удирдлагын санхүүгийн мэдлэг дутмаг, нягтлан бодогч нарын санхүүгийн сахилга бат сул, түүнд хариуцлага тооцдоггүй байдал
- ✓ Төрийн байгууллагуудын уялдаа холбоо, мэдээлэл солилцоо хангалтгүй байдал
- ✓ Нягтлан бодох бүртгэл хөтлөхдөө нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, холбогдох стандарт, дүрэм журмыг бүрэн мөрддөггүй байдал
- ✓ Харилцагч талуудтай тооцоо нийлж акт үйлдэж тайлагнаагүй байдал
- ✓ Удирдлагын үе шатны хяналт хангалтгүй, албан тушаалтан хуулиар хүлээсэн үүргээ бүрэн хэрэгжүүлээгүй байдал
- ✓ Аудитаар илэрсэн алдаа зөрчлийг арилгах тал дээр ажил зохион байгуулсан

ЦААШИД АВЧ ХЭРЭГЖҮҮЛЭХ АРГА ХЭМЖЭЭ

Санхүүгийн тайлангийн аудитаар илэрдэг нийтлэг алдаа зөрчлийг арилгах талаар дараах арга хэмжээ авч хэрэгжүүлэхийг зөвлөж байна. Үүнд:

- ✓ Иргэдийн Төлөөлөгчдийн хурлаар санхүүгийн тайлангийн аудитын дүнг хэлэлцүүлэн шийдвэр гаргах
- ✓ Зөрчлийг бууруулах талаар аймгийн Засаг даргын шийдвэр гаргаж хэрэгжилтийг хангуулах
- ✓ Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилтийг хангаж, хяналт тавьж ажиллах
- ✓ Төсвийн орлогыг нэмэгдүүлэхэд татвар, хураамж, түрээс төвлөрүүлдэг байгууллагуудын бааз суурийг шинэчлэх, бэхжүүлэх, үнэн зөв болгох
- ✓ Төсвийн ерөнхийлөн захирагчийн хүрээний байгууллагуудад дотоод хяналтыг системтэйгээр хэрэгжүүлэн зөрчил давтан гаргахгүй байхад анхаарч ажиллах
- ✓ Харьяа байгууллагын улирлын төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайланг хүлээн авч хяналт тавьж ажиллах
- ✓ Хөрөнгө оруулалтаар бий болсон хөрөнгийн бүртгэл, хөрөнгийн тооллогын дүнд Орон нутгийн өмчийн газар хяналт тавьж ажиллах
- ✓ Сум хөгжүүлэх сан, мал хамгаалах сан, тариалан эрхлэлтийг дэмжих сан, хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сан, нөхөн олговортой холбоотой хуулийн байгууллагад хандах шаардлага үүссэн болон шийдвэр гарсан асуудлыг нэгтгэн биелэлтэд хяналт тавьж ажиллах.
- ✓ Аймгийн ИТХ-ын тогтоол, Засаг даргын албан даалгаврын биелэлтийг улирал бүр тооцож ажиллах



ТЭМДЭГЛЭЛ

This image shows a full page of white paper with horizontal dotted lines. The lines are evenly spaced and run across the width of the page, providing a guide for handwriting practice. There are no margins, text, or other markings on the page.

ГОВЬ-АЛТАЙ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

